

## НЭГЭН ЖАРНЫ ӨНГӨНД

Алтангэрэл овогтой Пэрлээ би Төв аймгийн Баянцагаан сумын 2-р багийн нутаг Чулуут-Цагаан Дэл гэдэг газар төрсөн малчин удамтай ард хүний хүүхэд юмаа. 10 жил, Монгол Улсын Их Сургуулийн Геологийн ангийг дүүргэсэнээр ажил амьдралын замд орлоо. Энэ бол 1968 он байв. Их Сургуульд оюутан байхад минь миний багш Жаргалын Лхамсүрэн, Самдангийн Дашдаваа, Ренчингийн Барсболд, Ононгийн Төмөртоогоо зэрэг Монголын геологийн шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн аваргууд-алдартнууд маань надад багшилж гарыг минь ганзганд, хөлийг минь дөрөөнд гишгүүлж хүний зэрэгт хүргэсэн билээ. Би багш нартаа хамгийн эрхэм дээд хүндэтгэлээ хүргэж тандаа мэхийн ёслом уу.

А.Пэрлээ миний амьдралын хамгийн үр бүтээлтэй жилүүд болох 1969-2006 оны хооронд Монгол Улсын ШУА-ийн геологийн хүрээлэнд болон МУИС-даа ажиллаж амьдарсан хугацаанд би өлөг гүрвэлийн судалгааны ангилал зүй-морфологи хөгжил, хөдөлгөөний анатомын тайлал боловсруулах, жижиг махчин динозавраас нисдэггүй шувуу Мононикас хэрхэн үүсч бий болсон, улиран хувслын хөгжлийн асуудлаар онолын судалгаа хийж ирэв.

1. 1970-1977 онд Аллектрозавр гэгч аврага махан идэшт динозаврын араг ясны харьцуулах морфологийн судалгаа хийж Хятадын “Эрээн давс” формаци, Монголын “Баянширээ” формацийн геологийн орчин, палеоэкологийн онцлог адилхан байх үндэслэлийг гаргасан билээ.

2. 1973-1975 онуудад Монгол-Зөвлөлтийн палеонтологийн хамтарсан экспедиц Ханбогдын нутаг, Амтгай, Байшин цав гэсэн газруудад эрэл, хайгуулын малталт хийсний дүнд Сегнозавр, Эрликозавр, Энигмозавр гэсэн 2 овогт хамаарах 3 төрөл, 3 зүйл амфибионт холимог идэшт (омнибора) Төв Азийн унаган динозаврын ангилал, морфологийн харьцуулах судалгааг 8 жилийн дотор хийж дэлхийн динозавр судлалын сан хөмрөгт өөрийн өмчтэй болсон билээ.

Мөн энэ жилүүдэд “Өлөг гүрвэлийн мөрөөр” “Extinct World History” гэсэн нийт 40-өөд минутын шинжлэх ухааны хоёр баримтат киног улсын кино үйлдвэрээр хийлгэсэн. Би кино зохиолыг нь бичиж кинонд зургийн тайлбарыг Монгол, Англи хэлээр уншсан байдаг юм.

1985, 1999 онуудад сургалт, судалгаанд зориулсан Монголын палеонтологийн картыг 1:3000,000., 1:500,000-ны масштабтайгаар бүтээн улсын геодези-зүраг зүйн газраар хэвлүүлсэн билээ.

3. 1970-1971 онд Монгол-Польшын ШУА-иудын хамтарсан палеонтологийн экспедиц-д Монголын ШУА-ийн талыг төлөөлөн оролцож хээрийн судалгааны үед малтаж авсан хатуу гавалт динозавр-Пакицефалозаврын нэгэн шинэ төрөл-Гоёоцефалын ясан биеийн харьцуулах морфологийн судалгаа хийснээ 1983 онд Польшын ШУА-ийн Acta-Palaeontologica Polonica сэтгүүлд хэвлүүлсэн билээ.

4. 1981-1989 онуудад Монгол-Зөвлөлтийн палеонтологийн хамтарсан экспедицид ажиллаж байхдаа Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг Хүрэн Дух гэдэг доод цэрдийн олдворт газраас шүдтэй-Орнитомимид-Гарпимимид-н нэгэн шинэ овгийн амьтны судалгааг Р.Барсболдын хамт хийснээ Оросын ШУА-ийн хэвлэлд хэвлүүлсэн байна.

5. Мөн энэ жилүүдэд эрж малтаж авсан нэгэн төрлийн жижиг махчин динозавр (Манираптор)-н маш муу чулуужсан 30% орчим бүтэн араг ясанд морфологи судалгаа хийж 1999, 2006 онд хэвлүүлсэн болно.

1987 онд Өмнөговь аймгийн Гурван Тэс сумын нутаг Бүгийн цавын дээд цэрдийн хурдсаас эрж малтаж аван хожим нь Мононикас гэж нэр өгсөн нисдэггүй шувууны эволюци хөгжлийн эхлэлыг тавьсан амьтны харьцуулах морфологийн судалгааг хийсэн анхны бүтээлээ Английн шинжлэх ухааны хамгийн үнэтэй сэтгүүл "Nature"-т 1993, 1994 онуудад хэвлүүлсэн болно.

Чухам энэ судалгаа минь надыг 2002 онд дэлхийн ууган их сургуулиудын нэг болох 1209 онд албан ёсоор үндэслэн байгуулагдсан Английн Кембриджийн Их Сургуулийн Эзэн Хааны нэрэмжит коллежийн алтан медаль, 21-р зууны гарамгай эрдэмтэн гэсэн Диплом, сертификат олгосон болов уу.

Би Монгол Улсын Их Сургуульдаа багшилж эхэлсэн он жилүүддээ 1994 оноос одоог хүртэлх хугацаанд:

1. 1999 он Шим мандал дахь тафономын үндсэн асуудал (7хх)
2. 2000 онд Далайн сээр нуруугүй амьтны палеонтологи (11хх)
3. 2002 онд Дэлхийн геологийн хөгжлын түүхэн товчоон (15хх)
4. 2002 онд Тусгай хамгаалттай газар нутгийн сүлжээ. Хамтран зохиогчоор (18хх)

5. 2005 онд Сравнительная морфология поскраниального скелета все-ядных форм динозавров-Сегнозавров. Монографи (6.5xx)

6. 2005 онд Функциональная анатомия динозавров-ящеротазовых. Монографи (15xx)

7. 2006 онд “Flightless-bird Mononykus” нэг сэдэвт зохиол, Англи хэлээр.

Монографи (18.3xx) зэрэг сурах бичиг, унших бичиг, гарын авлага, эрдэм судлалын нэгэн сэдэвт зохиолуудыг бичиж хэвлүүлсэн төдий болно.

Мөн 2000 онд Монголын Их Нэвтэрхий Толь зохиосон 550 эрдэмтний тоонд багтсанаа их аз гэж бодож байна. Ийм завшаан тэр бүрий хүнд оногдохгүй л болов уу.

Би шинжилгээний ажилд сэтгэлээ зориулснаас хойш эдүгээ 40 жил болжээ. Анх 1967 онд МУИС-ийн оюутны эрдэм шинжилгээний онолын бага хуралд II байр эзэлж байснаас цагийн тооллол минь эхэлсэн байна.

Би 40 жилийн хугацаанд дэлхийн олон улсын 3 том их хуралд оролцож байв. Үүнд:

1. 1974 онд Москва хотноо 12 хоног хуралдсан **Палеонтологийн-араантан амьтан судлалын анхдугаар их хурал**

2. 1996 онд Бээжин хотноо 12 хоног хуралдсан **дэлхийн геологичдийн 30-р их хурал**

3. 1993 онд Тайланд улсын Бангкок хотноо 14 хоног хуралдсан **UNESCO-ийн Ази Номхон далайн орнуудын 6-р их хуралд тус тус оролцжээ.**

*Мэгээд Жанрайсаг* бурханыг шинээр дахин бүтээх үйл ажиллагааны тухай болон аль 1945 онд тэр бурханыг хууль бусаар гадаадад гаргасан асуудлыг анх удаа UNESCO-ийн дэлхийн 70 гаруй орны төлөөлөгчдийн сонорт хүргэж тэр их хурлын индэрээс 12 минут илтгэл тавьж хэлэлцүүлсэн нь миний насан туршийн бахархах бахархал юм гэж боддог доо.

Би динозавр судлалын 40 жилийн дотор “Монголын динозаврын геологийн орчин”, “Экологийн орчин” гэсэн сэдвээр Япон оронд 1984-1985 онуудад үзэсгэлэн гаргах ажлаар Япон улсын 20 хотод 1 сая гаруй үзэгчдэд үзүүлж таниулах ажилд оролцож байсан билээ. Энэ үзэсгэлэнгийнхээ үргэлжлэл маягаар Монгол орондоо Эрдэнэт, Орхон, Дархан, Сэлэнгэ зэрэг аймгийн хөдөлмөрчдөд нүүдлийн маягаар сурталчилгаа хийх ажилд мөн гар бие оролцсон юм.

1979 онд хуучнаар ДСНК-д 14 хоногийн турш Монгол-Зөвлөлтийн Палеонтологийн хамтарсан экспедицийн 10 жилийн ойд зориулан палеонтологийн үзэсгэлэнг зохион

байгуулах бүх ажилд оролцож, тэнд байрлуулсан 6 төрлийн динозаврын хэлхээ ясан биеийг угсарч босгох ажилд Орос, Монгол нөхдийн хамт гар сэтгэл нийлэн ажиллаж байлаа. Энэ үзэсгэлэнд анх удаа Шарын Голоос олж авч ирсэн (лаборант Б.Намсрай гуайтайгаа хамт ухаж, малтаж авсан 35 мянган жилийн өмнөх) эртний аврага савагт Хирсний бүтэн араг ясыг тавьж олны хүртээл болгож байв.

1981 онд Монгол улсын Төв Музей дотор Лениний музейн 5 зааланд Палеонтологийн Музейг шинээр байгуулахад, Р.Барсболд Орост докторын ажлаа хамгаалах их хүнд ажлыг дуусгаж байх цагт би ШУА-ийн Геологийн Хүрээлэнгийн бүх ажилчдынхаа хүчээр музей байгуулах ажлыг хүрээлэнгийн захиргааны даалгавараар удирдан гүйцэтгэж байлаа.

Миний үр бүтээлт амьдралын 40 жилд арын албанд минь сэтгэл гарган зүтгэсэн хайрт гэргий нефтийн хэмээх Ц.Алтанцэцэг, миний 4 хөвгүүн Чинболд, Мөнболд, Өнөболд, Эрболд, охин Наранчимэг нартаа хамгийн сайн сайханыг хүсч хайраа дотроо хадгалж, халаа гаднаа үзүүлж эцгийн ёсоор энхрийлж, ханийн ёсоор халамжилж байдаг билээ. Энэ бол миний амьдрал юм.

БИОЛОГИЙН УХААНЫ ДОКТОР, ПРОФЕССОР А.ПЭРЛЭЭГИЙН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

I.НЭГ СЭДЭВТ ЗОХИОЛ

Перлэ.А, Сравнительная морфология динозавров и особенности их локомоций.

Автореферат Докторской диссертаций Москва “Наука” 30 стр

Перлээ.А, 2000. Шим мандал дахь палеоэкологи, тафономийн үндсэн асуудлууд.

Улаанбаатар. 2хх

Перлээ.А, 2002. Дэлхийн геологийн хөгжлийн түүхэн товчоон. УБ. 15хх

Перлээ.А, 2000. Тусгай хамгаалттай газар нутгийн сүлжээ. УБ. 18хх

Perle.А, 2006. Flightless bird-Mononykus. Ulan-Bator. 18.3pp

II. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Perle.А, 1977. 80 mln.s years in mortal compat Journal Mongolia. Ulan-Bator Mongolia,

N.11 28pp

Перлэ.А, 1977. О первой находке Алектрозавра из верхнего мела. “Проблемы

геологии Монголии” ШУАХ; 1.0 печ.лист.

Перлэ.А, 1979. Сегнозаврид-новое семейство мела теропода из позднего мела

Монголии. Москва. “Наука” 1.5 печ.лист

Перлэ.А, 1979. Segnosauridae - новое семейство позднемеловых хищных

динозавров Монголии.-В кн: Фауна мезозоя и кайнозоя Монголии. Тр. ССМПЭ, вып. 8. М., Наука, 1979, с.45-55

Перлэ.А, 1979. Модификации таза зауриский и параллельная эволюция хищных

динозавров. Москва. “Наука” 1.0 печ.лист.

Perle.А, 1980. Segnosauria a new infraorder of carnivorous dinosaurs. Act paleontol.

Polonica Warszawa 1.5 p.p

Перлэ.А, 1981. Новый сегнозаврид из верхне-меловых отложений Монголии.

Москва. “Наука” 1.5 pp

Перлэ.А, 1981. Новый сегнозаврид из верхнего мела Монголии.-В кн: Ископаемые

позвоночные Монголии. Тр. ССМПЭ, вып.15.М., Наука, 1981, 50-59

Perle.А, 1982. A new flat-head dinosaur (Pachycephalosaurus Ornithischia)

Goyocephale lattimorei gen.sp.nov from the upper cretaceous of Mongolia. Act Paleont. Polonica. 1.5 pp

Перлэ.А, 1982. О находке задней конечности теризинозавра из верхнего мела

Монголии. – Тр, ГИН АН МНР, вып. 5,с. 94-99

Перлэ.А, 1983. К вопросу о происхождении птиц. – Вестн. АН МНР, №2, с.20-24

Перлэ.А, 1983. Энигмозаврид-новое семейство теропод из верхнего мела

Монголии. Москва. “Наука”, 0.6 печ.лист.

Перлэ.А, 1983. О тафономии совместного захоронения детенышей гадрозавров и

- некоторых. Москва. "Наука", 0.6 печ.лист.
- Перлэ.А, 1984. Новое семейство беззубых хищных динозавров-гарпимимид из нижнего мела. Монголии. Москва. "Наука", 0.8 печ.лист.
- Перлэ.А, 1985. Сравнительная миология тазобедренной области бипедальных форм динозавров-Палеонтол. Ж., 1985, №1. С.108-112
- Перлэ.А, 1988. О некоторых анатомических чертах прыжкообразного передвижения хищных динозавров. – Томск. вып. 9, с. 112-118.
- Перлэ.А, 1988. Морфологические особенности пситтакозавров Азии. "Проблемы геологии МНР" ШУАХ; 0.9 печ.лист.
- Перлэ.А, 1989. Миология и эволюция тазобедренных структур хищных динозавров. Москва. "Наука", 0.2 печ.лист.
- Перлэ.А, 1990. Об особенностях локомоторного аппарата у утконостных динозавров на примере гадрозавров. Москва. "Наука", 0.6 печ.лист.
- Перлэ.А, 1991. Сравнительная морфология локомоторного аппарата заурисхий. Москва. "Наука", 1.5 печ.лист. Ж, МОИП №5
- Perle.A, 1992. The morphological peculiarities of the Velociraptor Mongoliensis from the upper cretaceous of Mongolia. Canada Toronto. Can,J earth Sci V. 18 pp 68-69
- Perle.A, 1993. Flightless bird from the upper cretaceous of Mongolia. Nature. Vol 623-628
- Perle.A, 1993. Mononychus name correction to Mononykus olecranus a short terminal correction. Nature. London vol 362
- Perle.A, 1993. Cranial morphology of the mononykus olecranus. American Museum Novitates in press.
- Perle.A, 1994. Skeletal morphology mononykus olecranus (Theropodus Avalae) from the late cretaceous of Mongolia. American Museum Novitates New York Nu 309 2.0pp
- Perle.A, 1994. The skull of Erlicosaurus endrewsi a late cretaceous Segnosaurian dinosaurs from the Mongolia. American scientists. Nu 3115 pp 39
- Perle.A, 1994. Theropod dinosaur embryo and affinities of te flaming cliffs dinosaurs eggs. Sceince Vol. 226, p.701-740. USA
- Perle.A, 1995. The phylogenetic relationships of Segnosaurus Theropod Therizinosauridae. Jornal Vertebrate Paleontology, N15, p.89-95
- Perle.A, 1995. On the new from the flightless bird from the upper cretaceous of Mongolia. Proceedings of the annual Vertebrate Paleontol Symp. Canada, 0.2 pp
- Perle.A, 1995. Extraordinary preservation in a new vertebrate assemblage. NATURE Vol.374, p.446-449 London UK.
- Perle.A, 1995. On some problems of comparative morphology and evolution of the lizard-hipped dinosaurs. Proceeding of 2-ND inter.scien.confer. of the west. Mong. P.117-119. Khobd
- Perle.A, 1995. Proceratops and Viloceraptor preserved in association and evidens for predator /behavior in Dromaeosaurid dinosaurs. Journ. Of Verterate Paleontology N15, Part 3, p.117-126. Pittsburgh USA.

- Perle.A, 1995. Theropod dinosaur embryo and affinities of the flaming cliffs dinosaurs eggs. Science Vol. 166, p.712-740.
- Perle.A, 1996. The morphological and Locomotoral peculiarities of the saurischian dinosaurs-pelvic structure. Special papers to the 30<sup>th</sup> . international Geological Congress. Problems of geology and mineral resources of Mongolia. P.13-15
- Пэрлэ.А, 1996. Развитие трохантеров бедра динозавров и их отношение к проблеме происхождения птиц. МУИС Байгалийн ухаан. №2/118/, х.60-79
- Пэрлэ.А, 1997. On the origin bird flight. Ховд хот Баруун Монголын байгалийн ресурс олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд.
- Perle.A, 1997. On some problems of the archaeopteryx bird flight manners. Provincial press Khobd. Page 67-70
- Perle.A, 1998. The primitive models of the pelvic and limb structures muscles of reptiles (lizard, crocodiles and bird). ТУШУТИС-ийн бүтээл
- Perle.A, 1998. Musculature and its significance on the most progressive Archaeopteryx locomotion. Geoscientist project of institute of Geology and Mineral resources
- Perle.A, 1999. Morphology of Achillobator from the upper cretaceous of Burkhan formation of Mongolia. National University press.p.96
- Пэрлэ.А, 1999. О новом местонахождении-мамонтовых фаун западной Монголии. Г.Томск
- Пэрлэ.А, 1999. Динозавр нисдэггүй шувууны хөгжлийн эхэнд байсан нь. МУ-ын ШУА. Геологийн хүрээлэнгийн бүтээл. №13. Х.75-80
- Пэрлэ.А, 2000. Биосфер дахь палеоэкологийн болон тафономын судалгааны аргууд. УБ. Геоэкологийн асуудал. МУИС-ын бүтээл. №2 хх,7
- Пэрлэ.А, 2005. Сравнительная морфология посткраниального скелета всеядных форм динозавров-сегнозавров. С 1-111.